



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/387

Номгон

Салбар дундын ажлын хэсэг байгуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутаг дахь сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдийн эрхийг хангах, сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд, түүний дэргэдэх дотуур байрны үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж ажиллах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ажлын төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулж, тайлан, судалгаа мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн дарга (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН




Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар
сарын 20 ны өдрийн 018 дугаар захирамжийн
нэгдүгээр хэсэрт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-------------------------------------|---|
| Ажлын хэсгийн дарга
В.Наранчимэг | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Гишүүд: | |
| Н.Одончимэг | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүүхэд, залуучууд, гэр бүл, жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Ж.Алтанцэцэг | Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга |
| Б.Мөнхбаяр | Цагдаагийн газрын дарга |
| Д.Мөнхцэцэг | Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Н.Энхжаргал | Эрүүл мэндийн газрын дарга |
| н.Содонцэцэг | Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан |
| Нарийн бичгийн дарга
Н.Мэндбаяр | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Хүүхдийн эрхийн улсын байцаагч |

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 20 -ны өдрийн 143/21 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



СҮМ ХИЙД, ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ТАВЬЖ, ХҮҮХДИЙН ЭРХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад заасан чиг үүргийн хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд, түүний дэргэдэх дотуур байрны үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж ажиллах

№	Ажил, арга хэмжээ	Хугацаа	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах
1	2	3	4	5	6
1	Салбар дундын ажлын хэсэг байгуулах	VIII-сар	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм, хийдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, алдаа зөрчлийг илрүүлэх, холбогдох арга хэмжээг авах	Нийгмийн бодлогын хэлтэс	1.Цагдаагийн газар 2.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 3.Боловсрол, шинжлэх ухааны газар 4.Соёл урлагийн газар 5.Эрүүл мэндийн газар 6.Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан
2	Орон нутгийн сүм хийдүүдэд хяналт шалгалт хийх	VIII, IX, X-сар	Хяналт шалгалтыг 2-3 удаа зохион байгуулж, дүнг танилцуулах	Салбар дундын ажлын хэсэг	
3	Сүм хийдэд шавилан суралцаж байгаа хүүхэд болон өдрөөр үйлчлүүлж байгаа хүүхдийн бүртгэл мэдээллийн сан үүсгэх	IX, X-сар	Судалгаа, мэдээллийн санг цахимжуулсан байх	Соёл урлагийн газар	1.Цагдаагийн газар 2.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
4	Сүм хийдийн байгууллага бүрийг "Хүүхэд хамгааллын бодлого"-той болгох, мөрдүүлэх, мэргэжил арга	VIII, IX, X-сар	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг боловсруулж, батлуулсан байх	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Боловсрол, шинжлэх ухааны газар

1	2	3	4	5	6
	зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавих ажлыг зохион байгуулах				
5	Сүм хийдийн хурал, цуглааны лам санваартан, номлогч (пастор), шашны сургуулийн багш, бусад туслах ажилтанд хүүхдийн эрх, хамгааллын талаарх сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулж, чадавхжуулах	VIII, IX, X-сар	Сургалтын хөтөлбөр боловсруулах, салбар бүрээр үе шаттай сургалтад хамруулж, үр дүнг тооцох	Боловсрол, шинжлэх ухааны газар	1.Цагдаагийн газар 2.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 3.Эрүүл мэндийн газар 4.Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан
6	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдийн судалгаа гаргах	IX-сар	Судалгаа, мэдээллийн санг цахимжуулсан байх	Соёл урлагийн газар	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
7	Зөвшөөрөл олгосон сүм хийдийн байгууллагатай "Хариуцлагын гэрээ" байгуулах Гэрээнд тусгах зүйл: -Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж ажиллах -сүм хийдэд шавилан суралцаж байгаа болон үйлчлүүлж байгаа хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг нуун дарах үйлдлийг хориглох; -хүүхдийн эрх зөрчсөн нь тогтоогдсон сүм хийдийн байгууллагын зөвшөөрлийг цуцлах.	IX-сар	Гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан байх	Цагдаагийн газар	1.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2.Боловсрол, шинжлэх ухааны газар 3.Эрүүл мэндийн газар 4.Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан
8	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн хэрэгжилтийг сайжруулах	IX, X-сар	Шашны сургуульд суралцагч сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавих	Боловсрол, шинжлэх ухааны газар	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
9	Сүм хийдийн үйл ажиллагааг эцэг, эх, олон нийтэд нээлттэй ил тод болгох	VIII, IX, X-сар	Мэдээлэл сурталчилгааны ажил хийсэн байх	Соёл урлагийн газар	1.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2.Боловсрол, шинжлэх ухааны газар

1	2	3	4	5	6
10	Сүм хийдийн үйл ажиллагаа болон түүнд шавилан суралцаж байгаа, үйлчлүүлж байгаа хүүхдийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээ авах дүгнэх	VIII, IX, X-сар	Сүм хийдийн үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байх	Соёл урлагийн газар	1.Эрүүл мэндийн газар 2.Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан
11	Салбар дундын ажлын хэсгийн тайлан хүргүүлэх	X-сар	Үйл ажиллагааны тайлан, судалгаа мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн байх	Салбар дундын ажлын хэсэг	